



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Аудитын нэр: "Сумдад уурын зуухны үйл ажиллагаа явуулж байгаа компаниудын үйл ажиллагаа, үр дүн" гүйцэтгэлийн аудит

ХӨА-2018/03/-ГА



"Шинэ-Идэр Дулаан-Эрдэнэт" ХХК-ийн зуухны барилга нь ажилтнуудын ажиллах нөхцөл, эрүүл ахуйн шаардлагыг хангахгүй байна.



Их-Уул дулаан ХХК-нд Мон-Ажнай ХХК-аас нийлүүлсэн нүүрс



"Тариалан НАҮТ" ХХК-ийн 2014 онд тавьсан зуух нь хугацаанаасаа өмнө ашиглах боломжгүй болсон байна.

*Монгол Улсын Ерөнхий аудиторовын
2018 оны 06 дугаар тушаал, аймгийн
ИТХ-аас ирүүлсэн саналыг үндэслэн
гүйцэтгэсэн гүйцэтгэлийн аудитын
тайлан*

**Сумдад үйл ажиллагаа явуулж
буй уурын зуухнуудын
зардлыг бууруулах
боломжтой байна.**

**Хөвсгөл аймаг
Мөрөн сум 2018**



Тайланг бэлтгэсэн:

**Хөвсгөл аймаг дахь
Төрийн Аудитын газар**

ХӨА-2018/03/-ГА

Хөвсгөл аймаг дахь Төрийн
аудитын газрын дарга бөгөөд
тэргүүлэх аудитор

О.Ганболд

Аудитын менежер

Г.Эрдэнэчимэг

Ахлах аудитор

Л.Энх-Амгалан

Аудитор

Э.Бат-Эрдэнэ

2018 оны 05 дугаар сар

**Уг тайланг УАГ-ын цахим
хуудаснаас үзнэ үү.**

www.audit.mn

Аудитын тайлан, дүгнэлттэй
холбоотой асуудлаар
70384043 дугаарын утас,
70383793 дугаарын факсаар
харилцана уу?

ХАЯГ: (Хөвсгөл аймгийн
ЗДТГ-ын А байр 3 давхарт)

АГУУЛГА

- ❖ Товчилсон үгийн жагсаалт 3
- ❖ Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, стандартын талаарх мэдээлэл 4
- ❖ Тайлангийн хураангуй 6

Ерөнхий зүйл

БҮЛЭГ-1. Компаниудыг чиг үүрэг, үйл ажиллагааны чиглэл, зорилгод нийцүүлэн зохион байгуулаагүй байна. 5

1.1. Компанийн удирдлагыг аймагт төвлөрүүлэхэд орон нутгийн удирдлагын саналыг харгалзаагүй байна. 5-7

1.2. Харилцагч байгууллагатай байгуулсан гэрээний үүргээ хэрэгжүүлэн ажилласан байна. 8-9

БҮЛЭГ-2. Компаниудын үр ашгийг дээшлүүлэх боломжтой байна. 9

2.1. Бизнес төлөвлөгөөг өмнөх оны гүйцэтгэл, жилийн дундуур хийсэн өөрчлөлтийг шинжлэн, хянахгүй баталж байна. 9-12

2.2 Үйлдвэрлэлийн зардлыг бууруулах боломж орон нутагт байна. 12-15

2.3 ТБОНӨХБАУХА тухай болон Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт хангалтгүй байна. 17-18

Дүгнэлт..... 19

Зөвлөмж..... 20-21

Холбогдох байгууллагаас ирүүлсэн санал
Хавсралт
Зөрчлийн жагсаалт.....
Тэргүүлэх аудиторовын тушаал



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОРЫН ТУШААЛ

2018 оны 06 сарын 04 өдөр

Дугаар А/06

Мөрөн сум

Аудитын тайлан баталгаажуулах тухай

Монгол Улсын Ерөнхий аудиторын 2018 оны А/06 дугаар тушаал, 2017 оны А/188 дугаар тушаалын тавдугаар хавсралтын 2.4 дэх заалт, 2016 оны А/92 дугаар тушаалаар баталсан “Гүйцэтгэлийн аудитын журам”-ын 12.40 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Тэргүүлэх аудиторын баталсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу “Сумдад уурын зуухны үйл ажиллагаа явуулж байгаа компаниудын үйл ажиллагаа, үр дүн”-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг баталсугай.
2. Аудитын тайланг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, аймгийн Засаг дарга, сумдад уурын зуухны үйл ажиллагаа явуулж байгаа компаниудын төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гүйцэтгэх захиралуудад тус тус хүргүүлсүгэй.
3. Аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаж үр дүнг 2018 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн дотор багтаан Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга (Л.Төмөрбаатар), сумдад уурын зуухны үйл ажиллагаа явуулж байгаа компаниудын төлөөлөн удирдах зөвлөлийн дарга (Н.Шинэбаяр), “Их-Уул дулаан” ХХК-ийн, “Тосон-Илч” ХХК-ийн, “Түнэл-Илч” ХХК-ийн, “Галт дулаан” ХХК-ийн, “Тэсийн-Илч” ХХК-ийн, “Тариалан НАУТ” ХХК-ийн, “Шинэ-Идэр дулаан эрдэнэт” ХХК-ийн гүйцэтгэх захирал нарт зөвлөсүгэй.
4. Гүйцэтгэлийн аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аудитын хэлтсийн дарга бөгөөд аудитын менежер (Г.Эрдэнэчимэг), ахлах аудитор (Л.Энх-Амгалан) нарт даалгасугай.

ДАРГА БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



О.ГАНБОЛД

Товчилсон үгийн жагсаалт

Товчилсон үг	Тайлбар
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
ТБОНӨХБАҮХАТ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
ҮАГ	Үндэсний аудитын газар
ГАГ	Гүйцэтгэлийн аудитын газар
ХөААГ	Хөвсгөл аймгийн аудитын газар
ГА	Гүйцэтгэлийн аудит
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ХАА	Худалдан авах ажиллагаа
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
СТСХ	Санхүү, төрийн сангийн хэлтэс
ОНӨГ	Орон нутгийн өмчийн газар
ИНХ	Иргэдийн нийтийн хурал
ТАХ	Төсөл, арга хэмжээ
ББӨ	Борлуулсан бүтээгдэхүүний өртөг
БО	Борлуулалтын орлого
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ЭМТ	Эрүүл мэндийн төв
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл

Хүснэгтийн тайлбар

Хүснэгт	Тайлбар
Хүснэгт-1	Компаниудын барилга, шугам сүлжээ, зуухны мэдээлэл
Хүснэгт-2	2017 оны бизнес төлөвлөгөө, гүйцэтгэл
Хүснэгт-3	Орлогоор хүлээн зөвшөөрсөн үйл ажиллагааны бус орлогуудын жагсаалт
Хүснэгт-4	Компаниудын орлого, зардал, үр ашгийн үзүүлэлт
Хүснэгт-5	Нүүрс, тээврийн хөлс, цалингийн судалгаа
Хүснэгт-6	Нүүрс тээвэрлэсэн зай
Хүснэгт-7	Үр ашгийн үзүүлэлт
Хүснэгт-8	Нүүрс зарцуулалт
Хүснэгт-9	ТУЗ-ийн зардлын төсөв
Хүснэгт-10	Хөдөлмөр хамгааллын хувцасны үнийн жагсаалт
Хүснэгт-11	Шилэн дансны мэдээлэл
Хүснэгт-12	Тэсийн-Илч” ХХК-ийн нэг сарын орлого, зардлын тооцоо

1. Аудит хийх үндэслэл, бүрэн эрх:

Аудитыг Монгол Улсын Ерөнхий аудиторын 2018 оны 06 дугаар тушаал, Монгол Улсын Ерөнхий аудиторт Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газраас 2018 онд нийлүүлэх бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний төлөвлөгөө, аймгийн ИТХ-аас ирүүлсэн саналыг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хийв.

2. Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандартын талаарх мэдээлэл

“Сумдад уурын зуухны үйл ажиллагаа явуулж байгаа компаниудын 2016, 2017 оны үйл ажиллагаа, үр дүнд аудит хийж дүгнэлт өгч, дүн дүгнэлтэд үндэслэн зөвлөмж боловсруулан холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулах, үр дүнг олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт оршино.

Уг зорилтыг хангахын тулд аудитыг дараах чиглэлээр гүйцэтгэлээ. Үүнд:

- ❖ *Компанийн удирдлага, зохион байгуулалт, бодлого, чиг үүрэг үр нөлөөтэй эсэх*
- ❖ *Компаниудын үйл ажиллагаа үр ашигтай эсэх*

Аудитаар сумдад уурын зуухны үйл ажиллагаа явуулж байгаа “Тариалан НАҮТ” ХХК, “Их-Уул дулаан” ХХК, “Тосон-Илч” ХХК, “Түнэл-Илч” ХХК, “Галт Дулаан” ХХК, “Тэсийн –Илч” ХХК, “Шинэ-Идэр Дулаан-Эрдэнэт” ХХК-ийн 2016, 2017 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан, худалдан авах ажиллагааны тайлан, бараа материал, үндсэн хөрөнгийн тайлан, компаниудын ТУЗ-ийн үйл ажиллагааг болон бусад холбогдох бичгүүдийг хамруулсан.

3. Аудитын арга зүй

Аудитыг гүйцэтгэхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт 300, 3000, 3100, Төрийн аудитын тухай хууль, гүйцэтгэлийн болон санхүүгийн аудитын арга зүйг ашиглан Тосонцэнгэл, Тариалан, Их-уул, Цэцэрлэг,Түнэл, Цагаан-Уул, Шинэ-Идэр сумын удирдлага, уурын зуухны үйл ажиллагаа явуулж байгаа компаниудын төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүд, гүйцэтгэх удирдлага, инженер техникийн ажилтан, холбогдох албан тушаалтантай хэлэлцүүлэг, ярилцлага хийх, асуулга, судалгаа тодруулга авах, хэрэгжүүлэгч байгууллагын тайлан, баримт материалд тулгуурлан баталгаажуулалт, дүн шинжилгээ хийв.

Аудитаар техник, тоног төхөөрөмжийн аюулгүй байдал, зуух болон дулааны сүлжээний горимыг боловсруулсан эсэхийг хянаагүй болно.

4. Шалгуур үзүүлэлтүүд

Аудитын зорилттой холбоотой дараах хууль тогтоомж, дүрэм, журам, зааврыг шалгуур болгон ашигласан. Үүнд:

- Төрийн аудитын тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- ТБОНӨХБАҮХАТ хууль
- Компаний тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Бусад хууль, эрхийн актууд

5. Аудитын бүрэлдэхүүн

Аудитыг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд тэргүүлэх аудитор О.Ганболд удирдаж, үе шатны болон явцын хяналтыг аудитын менежер Г.Эрдэнэчимэг хэрэгжүүлж, ахлах аудитор Л.Энх-амгалан, аудитор Э.Бат-Эрдэнэ нар 2018 оны 4 дүгээр сарын 05-наас 2018 оны 05 дугаар сарын 30-ны хооронд гүйцэтгэв.

6. Аудитын тайлангийн бүтэц, түүнд тусгагдах мэдээлэл, хэлэлцүүлэх журам

Аудитын тайлан нь аудитын зорилтууд, хамрах хүрээ, арга зүй, тайлангийн хураангуй, аудитын дүн, дүгнэлт, зөвлөмж, холбогдох байгууллагын санал, түүнд хийсэн тайлбар, хавсралт гэсэн агуулгаар үндсэн зорилтын дагуу бичигдсэн.

7. Үндсэн мэдээлэл

Хөвсгөл аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2016 оны 12 дугаар сарын 27-ны 98-104 дүгээр тогтоолуудаар сумдад уурын зуухны үйл ажиллагаа явуулж буй ОНӨААТҮГ-ыг “Тосон илч” ХХК, “Их-Уул дулаан” ХХК, “Тэсийн илч” ХХК, Галт дулаан” ХХК, “Түнэл илч” ХХК, “Эрдэнэт дулаан” ХХК, “Тариалан НАҮГ ХХК” болгон өөрчилсөн байна. Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2016 оны 12 дугаар сарын 27-ны 98-104 дүгээр тогтоолуудаар ХХК-ийн “Дүрэм” баталсан байна.

Сумдад уурын зуухны үйл ажиллагаа явуулж байгаа ХХК-иуд /Цаашид компаниуд гэх/-ын **2016 онд** мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 132,0 сая, авлага 95,0 сая, өглөг 63,0 сая, алдагдал 118,0 сая төгрөг, **2017 онд** мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 284,4 сая, авлага 77,0 сая, өглөг 40,4 сая, ашиг 33,9 сая төгрөг байна.

Компаниудын барилга, шугам сүлжээ, зуухны мэдээллийг харуулав. Хүснэгт-1

№	ХХК-ийн нэр	Барилга ашиглалтад орсон огноо	Шугам сүлжээ-ний урт	Зуухны марк, тоо, үнэ / сая төгрөгөөр				
				Ашиглалт ад орсон огноо	Марк	Хэрэгцээт хүчин чадал	Баланс ын үнэ	Үлдэх өртөг
1	Тэсийн-Илч ХХК	1975 он	2922 м	2007	MDZ-0.5	0,7 Гкал/ц	Данснаас хассан боловч ашиглаж байна.	
				2016	KBp-1		35,0	

				2016	КВр-0,8		35,0	бүртгэ эгүй
2	“Галт дулаан” ХХК	1971 он	623 м	2005	ДТХ-07-100	1,24 Гкал/ц	22,3	0
				2010	MDZ		144,0	0
				2012	НР-18-54		11,0	1,4
				2013	ВИЗУ-100		12,8	12,7
3	“Түнэл-Илч” ХХК	1987 он	1040 м	2006	АНДИ-1,8	0,4 Гкал/ц	20,0	10,5
				2012	БЗИУ-100		30,2	16,3
				2016	КВр-0,8		29,0	26,5
4	“Тосон-Илч” ХХК	1975 он	2263 м	2007	АНДИ-20	0,67 Гкал/ц	13,1	Барил гын хамт
				2009	НРЖ-60		9,7	1,0
				2015	НРЖ-85		21,1	16,2
5	Тарилан НАУТ ХХК	1972 он	2840 м	2011	ВИЗУ-100-2Ш	1,2 Г/кал/ц	50,0	18,7
				2014	ВИЗУ-100-2Ш		36,0	25,5
				2017	КВр-1		30,2	30,2
				2017	КВр-0,8		30,2	30,2
6	Их-уул дулаан ХХК	1961 он	2500 м	2014	Усан халаалтын тогоо-2ш	0,92Гка л/ц	84,6	67,4
				2007	АНДИ-20		47,0	25,7
				2009	КВ-06		121,1	71,9
				2017	ВИЗУ-100		ТУЗ шилжүүлж өгсөн	
7	Шинэ-Идэр дулаан эрдэнэт ХХК	1981 он	3200м	2011	ВИЗУ-100-2ш	0,71Гка л/ц	28,0	16,0

**Бүлэг 1: Компаниудыг чиг үүрэг, үйл ажиллагааны чиглэл, зорилгод
нийцүүлэн зохион байгуулаагүй байна.**

**1.1 Компанийн удирдлагыг аймагт төвлөрүүлэхэд орон нутгийн удирдлагын
саналыг харгалзаагүй байна.**

Сумдад уурын зуухны үйл ажиллагаа явуулж буй компаниудын дүрмийг аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2016 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 98-104 дүгээр тогтоолуудаар баталсан.

Компанийн дүрмийн 1.5¹-д дулааны эрчим хүч үйлдвэрлэх, түгээх борлуулах, үндсэн үйл ажиллагаанаас гадна, хүн амын ундны цэвэр усаар хангах, бохир ус зайлуулах ажиллагааг тухайн сумын ЗДТГ-тай байгуулсан гэрээний дагуу гүйцэтгэхээр заасан байна.

¹ “Компани нь дулааны эрчим хүч үйлдвэрлэх, түгээх борлуулах, үндсэн үйл ажиллагаанаас гадна, хүн амын ундны цэвэр усаар хангах, бохир ус зайлуулах ажиллагааг тухайн сумын засаг даргын тамгын газартай байгуулсан гэрээний дагуу гүйцэтгэж болно”

Захиргааны ерөнхий хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1 заалтыг² үндэслэн шийдвэр гаргах ажиллагаанд бодит нөхцөл байдлыг тогтоогоогүй, орон нутагт үүсдэг хүндрэл, бэрхшээлийг хэрхэн шийдвэрлэх талаар сум, орон нутгийн гүйцэтгэх удирдлагаас санал авахгүйгээр компанийн дүрмийг боловсруулсан нь дараах хүндрэлтэй асуудлуудыг бий болгосон байна. **Үүнд:**

- Компанийн дүрэмд заагаагүй сумын төвийн айл өрхийн хог цэвэрлэх, нохой устгах, халуун усны үйлчилгээг эрхэлж байна.
- Компанийн дүрмийн 1.6³ -д заасныг зөрчиж “Тариалан НАҮТ” ХХК, “Шинэ-Идэр Эрдэнэт дулаан” ХХК, “Тэсийн-Илч” ХХК –ууд нь сумын төвийн гэрэлтүүлгийн цахилгааны төлбөр, засвар үйлчилгээг хариуцан хэрэгжүүлсэн байна.
- Компанийн удирдлага нь Хувьцаа эзэмшигчдийн Хурал, ТУЗ-тай болсноор компанийн эрсдэлтэй асуудлыг богино хугацаанд шийдвэрлэж чадахгүй болсон байна.

Компаниудын ТУЗ чиг үүргээ үр нөлөөтэй бүрэн хэрэгжүүлээгүй, нэгдсэн удирдлагаар бүрэн хангаагүй байна. **Үүнд:**

- Компаниудын бизнес төлөвлөгөөг өмнөх жилүүдийн гүйцэтгэлтэй харьцуулахгүй, хянахгүй, шинжлэхгүй баталсан.
- Компаниудын техникийн шинэчлэл, ашиглалтын хугацаа дууссан зуух, тогоо, шугам сүлжээний шинэчлэлийн асуудлыг шийдвэрлээгүй, зуухны хүчин чадал, шугамын алдагдал, ямар хугацаанд ашиглагдаж, шинэчлэгдэж байгааг шинжлээгүй, техникийн норм, дүрэм баримталж буйг хянаагүй, ашиглалтыг сайжруулах талаар нэгдсэн арга хэмжээ аваагүй, мэргэжлийн байгууллагын дүгнэлт гаргуулаагүй байна. **Тухайлбал:**

-Уурын зуухнуудын тоног төхөөрөмжүүдийн найдвартай эсэх, аваар ослоос урьдчилан сэргийлэх талаар “Галт дулаан” ХХК-аас гаргасан хүсэлт, мэргэжлийн байгууллагын дүгнэлт, шугам сүлжээний шинэчлэлийг хэрхэн шийдвэрлэх талаар орон нутагтай харилцан санал солилцоогүй.

-Тариалан НАҮТ” ХХК-ийн конторын байр, “Шинэ-Идэр дулаан эрдэнэт” ХХК-ийн уурын зуухны барилга нь ажилтнуудын ажиллах нөхцөл, эрүүл ахуйн шаардлагыг хангаагүй байна.

- Компаниудын үйлчилгээний хөлс буюу үнэ тариф харилцан адилгүй байна. **Тухайлбал:** Ундны ус, халуун ус, айл өрх, аж ахуйн нэгж, төсөвт байгууллагуудаас авч буй дулааны үнэ тариф өөр өөр байна. */Хавсралт-3/*
- Санхүүгийн хяналт, аудитын албанаас “Их-Уул дулаан” ХХК-ийн халуун усны үйл ажиллагаанд хийсэн шалгалтаар илэрсэн зөрчлийн талаар аймгийн Орон нутгийн өмчийн газарт 2017 оны 5 дугаар сарын 23-ны өдрийн 1/113 тоот албан бичиг хүргүүлсэн боловч тодорхой арга хэмжээ аваагүй.
- “Сумын төвийн шинэчлэлийн ажил хийгдсэнтэй холбогдуулан “Тэсийн илч” ХХК-ийн уурын зуухны 2 тогоог аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2016 оны 12 дугаар

² “Захиргааны байгууллага захиргааны шийдвэр гаргах ажиллагаанд хамаарах бодит нөхцөл байдлыг тогтооно”

³ Компани нь энэ дүрэмд зааснаас өөр чиглэлийн үйл ажиллагаа эрхлэхийг хориглоно.

сарын 27-ны 94 дүгээр тогтоолоор данснаас хассан боловч уг хөрөнгийг одоо болтол ашиглаж байгааг шийдвэрлээгүй.

- Хог хаягдлын хураамжийн хэмжээг аль болох алдагдалгүй байлгахгаар тооцон төсөв батлах, гэрээ байгуулах талаар албан тоотыг сумдын ИТХ-ын дарга нарт хүргүүлсэн боловч шийдвэрлээгүй байна.

ТУЗ нь компаниудын дүрмийн 9-д заасан дараах эрх, чиг үүргийг хэрэгжүүлээгүй байна. **Үүнд:**

Дүрмийн 9.3.7 Компанийн эд хөрөнгийн болон эд хөрөнгийн эрхийн зах зээлийн үнийг тогтоох.

Дүрмийн 9.3.17 Компанийн дотоод хяналтын ажилтны сонгон шалгаруулж, түүнийг томилуулахаар гүйцэтгэх захиралд санал хүргүүлнэ.

Дүрмийн 9.3.18 Компанийн дотоод хяналтын дүрмийг ТУЗ баталж, дотоод хяналтын ажилтны цалин, урамшууллыг тогтооно.

Дүрмийн 9.3.21 Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн ажлыг дүгнэсэн байх

Дээрх асуудлуудад ТУЗ шийдвэр гаргахаар төлөвлөсөн байна.

Компаниудын ТУЗ менежментийн бодлого, нэгдсэн удирдлагаар хангах чиг үүргийн дагуу 2017 онд дараах ажлуудыг зохион байгуулж ажилласан байна. **Үүнд:**

- Бизнес төлөвлөгөө батлах, өөрчлөлт оруулах, гүйцэтгэлд хяналт тавих
- Шаардлагатай хөрөнгө зарцуулахаар гүйцэтгэх удирдлагаас ирүүлсэн хүсэлтийг шийдвэрлэх, орон нутгийн өмчит бусад компанид илүүдэлтэй халаалтын тогоо, яндан зэргийг шаардлагатай газар шилжүүлэн ашиглуулах, компанийн ТУЗ-ийн ажиллах журам баталсан.
- Ажилчдад тусламж, тэтгэмж олгох, хөрөнгө худалдан авах, засвар үйлчилгээ хийх зэрэгт шийдвэрүүд гаргасан байна. Энэ нь компанийн гүйцэтгэх удирдлагын чиг үүргийг хэрэгжүүлсэн байна.

Дээрх байдлаас харахад: Компаниудыг чиг үүрэг, үйл ажиллагааны чиглэл, зорилгод нийцүүлэн зохион байгуулаагүй байна.

1.2 Компаниуд харилцагч байгууллагуудтай байгуулсан гэрээний үүргээ хэрэгжүүлэн ажилласан байна.

Компаниуд харилцагчидтай дулааны эрчим хүч болон цэвэр усаар хангах гэрээ байгуулан ажиллаж байна.

Гэрээнд: Хангагч байгууллага нь дулааны журналыг байнга хөтлөх, өдөр бүр хяналт тавьж ажиллах, уурын зууханд гарсан саатал, гэмтлийг засварлах, гэрэл цахилгаан тасарснаас үүдэн халаалт зогссон тохиолдолд хэрэглэгч байгууллагад заавал мэдэгдэнэ зэрэг эрх, үүргийг тусгасан байна.

Гэрээний тусгай нөхцөлд: Тасалгаа, танхимуудын температур төгсгөлийн цэгүүдэд доод хэмжээ нь 20 градусаас доошгүй байх, тасалдахгүй байх, эрүүл ахуйн

шаардлагыг хангасан байхаар тусгасан байна. Мөн хэрэглэгчийн хүлээх үүрэгт шугаманд дулаан хэмжигч тавьж байршуулах талаар тусгасан байна.

Их-Уул сумын ЭМТ, ЕБС –аас халаалт хангалтгүй, хүйтэн байгаа талаар гомдол гарсан ч ТУЗ нь гэрээний үүргийн биелэлтийг хангалттай гэж дүгнэсэн байна.

Уурын зуухны үйл ажиллагаа явуулдаг компаниудын гүйцэтгэх захирлууд сумын Засаг даргатай болон ТУЗ-тэй гэрээ байгуулан ажиллаж, гэрээг дүгнэсэн байна.

Зарим хэрэглэгч нь гэрээний үүргээ хэрэгжүүлээгүй байна.

Компаниуд харилцагч байгууллагатай “Дулаан эрчим хүчээр хангах” гэрээг жил бүрийн 9 дүгээр сарын 15-аас дараа оны 5 дугаар сарын 15-ны өдөр хүртэлх хугацаанд байгуулан ажиллаж байна.

Гэрээнд талбайг халаах дулааны үнийг төсөвт газруудад 1430 төгрөгөөр, аж ахуйн нэгжүүдэд “Тосон-Илч” ХХК 770 төгрөгөөр, бусад компаниуд 825 төгрөгөөр, айл өрхөд 308 төгрөгөөр тус тус тооцож гэрээ байгуулсан байна.

Уурын зуухны үйл ажиллагаа явуулж байгаа компаниуд нь үйлчилгээний хөлсийг сар бүр гэрээнд заасан хугацаанд нэхэмжилж байгаа боловч, зарим төсөвт байгууллагуудын төсөвт халаалт, цэвэр усны зардал бүрэн тусгагдаагүйгээс гэрээний үүрэг нь хангагдаагүй байна. **Тухайлбал:**

- Тариалан сумын 12 жилийн ахлах сургууль 2017 онд 15,3 сая төгрөгийн халаалт, цэвэр усны төлбөрийг нэхэмжлэхийн дагуу төлөөгүй байхад “Тариалан НАҮТ” ХХК орлогоор тооцоогүй орхисон байна.
- Тариалан сумын соёлын төв шинээр ашиглалтад орсон боловч халаалт, цэвэр бохир усны зардал төсөвт тусгагдаагүй, орлого төвлөрөөгүйгээс одоогийн байдлаар халаалтын 53,3 сая төгрөгийн авлагатай байна.

Бүлэг 2: Компаниудын үр ашгийг дээшлүүлэх боломжтой байна.

2.1 Бизнес төлөвлөгөөг батлахдаа өмнөх оны гүйцэтгэл, жилийн дундуур хийсэн өөрчлөлтийг шинжлэн, хянахгүй баталж байна.

Компаниудын төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоолоор 2017 он, 2018 оны бизнес төлөвлөгөөг баталсан байна.

Сумдад үйл ажиллагаа явуулж буй уурын зуухнуудын бизнес төлөвлөгөөг компанийн гүйцэтгэх захирал, нягтлан бодогч нар боловсруулж, ТУЗ хянан баталж байна.

Компаниудын 2017, 2018 оны бизнес төлөвлөгөөг батлахдаа үйл ажиллагааны орлого, зардлын гүйцэтгэлийг өмнөх онтой зэрэгцүүлсэн боловч жилийн дундуур орсон өөрчлөлт, зардлын төлөвлөгөө, гүйцэтгэлээ зөв тайлагнасан эсэхийг хянаагүй байна. **Тухайлбал:**

- “Түнэл-Илч” ХХК 2016 оны гэрэл цахилгааны зардлын төлөвлөгөөг 17,5 сая төгрөгөөр баталсан, гүйцэтгэл 12,6 сая төгрөг байхад 17,5 сая төгрөгөөр тайлагнасныг хянаагүй байна.
- “Галт дулаан” ХХК-ийн 2017 оны бизнес төлөвлөгөөнд цалингийн зардлыг 25.4 сая төгрөгөөр дутуу тооцож, санал ирүүлснийг хянахгүй хэвээр нь баталсан.
- “Тэсийн-Илч” ХХК-ийн тоон үзүүлэлтүүд нь аудитаар баталгаажуулсан тайлангийн дүнгээс зөрүүтэй байна.

Компаниудын бизнес төлөвлөгөөний биелэлтийг өмнөх онтой харьцуулахад орлого 122,7 сая төгрөгөөр, зардал 59,6 сая төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна. *Хавсралт-4 өөс харна уу!*

Компаниуд 2017 оны бизнес төлөвлөгөөний орлогыг 7,2 хувиар буюу 153,2 сая төгрөгөөр давуулан биелүүлсэн, зардлыг 3,9 хувиар буюу 81,7 сая төгрөгөөр хэтрүүлсэн байна.

Компаниудын 2017 оны бизнес төлөвлөгөөний гүйцэтгэлийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт-2

2017 оны бизнес төлөвлөгөө, гүйцэтгэл

мян төгрөг

№	Компанийн нэр	Орлого			Зардал		
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
1	Их-уул дулаан ХХК	344,155.1	350,817.7	4,161.8	352,701	343,212	-9489,0
2	“Тэсийн-Илч” ХХК	270561.0	269537.2	-1023.8	251477.9	269390.9	17,913.0
3	Тосон-Илч ХХК	265,076.1	266,062.9	986.8	261,689.1	254,141.5	-7547.6
4	Тариалан НАҮТ ХХК	464,753.2	519,892.7	55,139.5	425,014.00	477,615.00	52601,0
5	Шинэ-Идэр дулаан эрдэнэт ХХК	261,903.00	260,089.50	-1813.5	253,610.00	258691,6	5051,6
6	Түнэл-Илч ХХК	190,221	190,854	633	174,781	174,584	0
7	Галт дулаан ХХК	351,492.71	446,578.02	95085.31	362,688.39	386,076.38	23,387.9
	ДҮН	2,148162,1	2,303,831,7	153,168,8	2,081,961.17	2,163711,4	81750,3

Хүснэгтээс харахад: “Их-уул дулаан” ХХК, “Тосон-Илч” ХХК, “Түнэл илч” ХХК–иуд ТУЗ-өөр батлуулсан бизнес төлөвлөгөөний хүрээнд зардал гаргаж ажилласан байна.

Бизнес төлөвлөгөөгөөр батлагдсан зардлыг дараах компаниуд хэтрүүлэн зарцуулсан байна. **Тухайлбал:**

“Шинэ-Идэр дулаан эрдэнэт” ХХК 5,0 сая, “Тэсийн–Илч” ХХК 17,9 сая, “Тариалан НАҮТ” ХХК 52,6 сая, “Галт дулаан” ХХК 23,4 сая төгрөгөөр тус тус хэтрүүлж, Компанийн дүрмийн 10.11.4–д заасан гэрээгээр хүлээсэн үүрэг, зорилтод түвшинг хангаагүй байна.

“Тэсийн–Илч” ХХК-ийн хувьд сумын төвийн шинэчлэл төслийн хүрээнд хийгдсэн цэвэрлэх байгууламжийн гэрэл цахилгааны зардал нэмэгдсэн, тоног төхөөрөмжүүдэд засвар хийсэн, үндсэн хөрөнгийн элэгдлээ төлөвлөөгүйгээс зардал хэтрэхэд хүргэсэн байна.

“Тариалан НАҮТ” ХХК байгалийн давагдашгүй хүчин зүйлээс үүдэн 21,1 сая төгрөгийг зарцуулсан, нүүрсний зарцуулалт, тээвэрлэлттэй холбоотой зардлуудаа хэтрүүлсэн байна. */Хавсралт№ 4-өөс харна уу/*

Компаниудын ТУЗ-ийн нийт зардал 8,0 сая төгрөгөөр хэмнэгдэж, “Галт Дулаан” ХХК-ийн ТУЗ-ийн 2017 оны 12 дугаар сарын 13-ний өдрийн 18 дугаар тогтоолоор ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Т.Өлзийбадрахыг Монгол-Вьетнам улсын хамтын ажиллагааг гүнзгийрүүлэх зорилгоор 1,5 сая төгрөгийг гадаад арга хэмжээний зардалд зарцуулсан байна.

Компаниуд нь 2016, 2017 онуудад дараах үйл ажиллагааны бус орлогыг бүртгэж тайлагнасан байна.

Орлогоор хүлээн зөвшөөрсөн үйл ажиллагааны бус орлогуудыг он тус бүрээр харьцуулан хүснэгтээр харуулав.

№	ХХК нэр	Агуулга	Хүснэгт-3 /сая төгрөг/	
			2016 он	2017 он
1	“Галт дулаан” ХХК	ОНХС-ийн хөрөнгөөр бэлтгэсэн үндсэн хөрөнгийг орлогоор хүлээн зөвшөөрсөн	97,7	29,4
2	“Тариалан НАҮТ” ХХК	ОНХС-ийн хөрөнгөөр бэлтгэсэн үндсэн хөрөнгийг орлогоор хүлээн зөвшөөрсөн		65,3
Нийт			97,7	94,7

Сумдад уурын зуухны үйл ажиллагаа явуулж буй компаниудын үр ашиг нэмэгдсэн нь ТУЗ-ийн үйл ажиллагааны үр дүнгээс төдийлөн хамаараагүй байна.

Компаниудын орлого, зардал, үр ашгийн үзүүлэлтийг хүснэгтээр харуулав.

Орлого, зарлагын үзүүлэлт	Хүснэгт-4 /сая.төг/		
	2016 он	2017 он	зөрүү
Борлуулалтын орлого	2,132.14	2,303.83	171,7
Нийт зардал	2,250.20	2,258,2	107,3
Татвар төлөхийн өмнөх ашиг /алдагдал/	-118,0	45,5	
Орлогын албан татвар	7,01	11,6	4,59
Татварын дараах ашиг/ алдагдал/	-125.1	33,9	158,9
Нөлөөллийг хасвал:			
Үйл ажиллагааны бус орлого	97,7	94,7	-3,0
Үндсэн хөрөнгийн элэгдэл, үндсэн хөрөнгө данснаас хассаны гарз	365,1	338,8	-26,3
Ашиг, алдагдал/Татварын дараах/	142,3	278,1	135,8

Компаниудын өөрчлөн байгуулагдаагүй байх үед **125,1** сая төгрөгийн алдагдалтай, өөрчлөн байгуулагдсанаас хойш **33,9** сая төгрөгийн ашигтай ажилласан байна.

Энэ нь үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал, үндсэн хөрөнгө данснаас хассаны гарзаас үүссэн зардлуудыг хасаж үр ашгийг тооцвол өмнөх онд нийт 142,3 сая төгрөгийн, 2017 онд 278,1 сая төгрөгийн тус тус **ашигтай** ажиллаж, ашиг 135,8 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Компаниудын орлого өмнөх оноос **171.7** сая төгрөгөөр нэмэгдэхэд дараах хүчин зүйлс нөлөөлсөн байна. **Үүнд:**

- Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар шинэ барилгууд баригдсан, өргөтгөл хийгдсэний дүнд халаалтын талбайн хэмжээ нэмэгдсэн байна. /Нэмэгдсэн талбайн хэмжээ **29436,6 м3** байна./
- ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжсэн төсөл, арга хэмжээг орлогоор хүлээн зөвшөөрч бүртгэснээс орлого нэмэгдэж компаниудын ашигт нөлөөлсөн байна. /Хүснэгт-4/

Зардлыг харьцуулбал: 2017 оны зардлын хэмжээ өмнөх оноос 34.4 /1919.5 - 1885.1/ сая төгрөгөөр өссөн байна. */Хавсралт №1-ээс харна уу/*

Тооцоолол: Үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал, үндсэн хөрөнгө данснаас хассаны /олз/ гарзыг нийт зардлаас хасаж тооцоолсон болно.

2017 оны зарим зардлуудын гүйцэтгэлийг өмнөх онтой харьцуулбал дараах байдалтай байна. Үүнд:

- “Тосон илч” ХХК-ийн нүүрсний зарцуулалт **240** тн-оор буурсан, бусад компаниудын нүүрсний зарцуулалт **28,0-220,1** тн-оор нэмэгдсэн байна.
- Компаниудын хөдөлмөр хамгааллын зардлын гүйцэтгэл **11,9** сая төгрөгөөр буурсан.
- Гэрэл цахилгааны зардал **25,6** сая төгрөгөөр нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

2.2. Үйлдвэрлэлийн зардлыг бууруулах боломж орон нутагт байна.

Сумдад уурын зуухны үйл ажиллагаа явуулж байгаа компаниуд Эрчим хүчний зохицуулах зөвлөлийн 2009 оны 06 дугаар сарын 08-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор баталсан дулаан эрчим хүчний үнэ тарифын дээд хязгааруудыг мөрдөж байна.

Харин “Тосон илч” ХХК хувийн хэвшлийн ААНБ-ын хувьд 770 төгрөгөөр буюу батлагдсан тарифийн доод хэмжээг мөрдөж байна.

Компаниудын цалингийн зардал, нүүрс тээврийн зардал, нүүрсний зарцуулалтад харьцуулсан шинжилгээ хийхэд харилцан адилгүй байна.

Нүүрс, тээврийн хөлс, цалингийн судалгаа

Хүснэгт-5 (мян.төг)

ХХК нэр	2016 он				2017 он				Нэгж тээврийн хөлс	
	Цалингийн зардал	Нүүрс тоо хэмжээ /тн-оор/	Үнэ	Тээврийн хөлс	Цалингийн зардал	Нүүрс тоо хэмжээ /тн-оор/	Үнэ	Тээврийн хөлс	2016 он	2017 он
"Их-Уул дулаан" ХХК	104,283.6	1,803.0	69116.0	19178.0	107472.2	2023.1	74793.0	21101.0	10.6	10.4
"Тэсийн илч" ХХК	114,919.7	1,143.2	37727.2	9899.7	119845.9	1354.0	44695.2	8360.0	8.7	6.2
"Тосон илч" ХХК	97,305.3	1,195.0	51660.0	27127.6	103716.2	955.0	32198.2	23920.8	22.7	25.0
Тариалан НАУТ" ХХК	162,523.1	1,920.0	72697.7	82937.0	154805.1	2010.1	76620.7	89848.9	43.2	44.7
"Эрдэнэт дулаан" ХХК	96,491.2	768.0	25335.0	15729.4	99131.0	734.4	24235.2	16141.0	20.5	22.0
"Галт дулаан" ХХК	132,397.8	1,412.0	46031.0	14223.6	137324.0	1600.1	52803.3	25778.4	10.1	16.1
Түнэл илч" ХХК	67,195.0	520.0	37925.0	15306.0	59922.0	638.0	36997.0	12760.0	29.4	20.0
Нийт	775,115.7	8,761.2	340491.9	184401.3	782216.4	9314.7	342342.6	197910.1	145.2	144.4
Дундаж	110,730.8	1,251.6	48,641.7	26,343.0	111,745.2	1,330.7	48,906.1	28,272.9	20.7	20.6

Хүснэгтээс харахад:

Үндсэн цалингийн дундаж зардлаас

- “Тосон-Илч” ХХК-ийн ажилтнуудын дундаж цалин нь 13,4 сая төгрөгөөр бага
- “Тэсийн илч” ХХК 4,2 сая төгрөгөөр их /худаг усан сан, халуун усаа түрээслүүлдэг/ байна.

“Тэсийн –Илч” ХХК 2016 онд 9,7 сая төгрөгийн, 2017 онд 10,2 сая төгрөгийн урамшуулал олгосон, бусад компаниудын хувьд ажилтнуудад урамшуулалт цалин олгоогүй байна.

Зарцуулсан 1 тн нүүрсэнд ногдох тээврийн зардлыг тооцоход: “Тэсийн- Илч” ХХК хамгийн бага буюу **6,2-8,7** мянган төгрөг байна.

“Тариалан НАУТ” ХХК 2016-2017 онуудад нүүрс тээврийн хөлсөнд 43,2-44,7 мянган төгрөг зарцуулсныг “Тэсийн-Илч ХХК”-тай харьцуулахад **4,9-7,1** дахин их зардал гаргасан байна. /Хүснэгт-5 /

“Их-Уул дулаан” ХХК-ийн нэгж тутамд ногдох зардал нь “Тэсийн –Илч” ХХК-ийхаас 1,9-4,2 мянган төгрөгөөр их байгаа нь нүүрсээ өөрийн тээврээр тээвэрлэж байгаатай холбоотой байна.

Нүүрс тээвэрлэсэн зай

Хүснэгт-6

№	Компанийн нэр	Нүүрс тээвэрлэж байгаа зай км-ээр		Нэгж тээврийн хөлсний зардал	
		Могойн гол ХХК	Мон-Ажнай ХХК	2016 он	2017 он
1	“Тэсийн-Илч” ХХК	22 км	0	8,7	6,2
2	Их-Уул дулаан ХХК	330 км	158 км	10,6	10,4

Хүснэгтээс харахад: “Их-Уул дулаан” ХХК-ийн нүүрс тээвэрлэх зай нь “Тэсийн –Илч” ХХК-ийн нүүрс тээвэрлэдэг зайнаас 136-308 км-ээр хол боловч 1 тн нүүрсний тээврийн хөлсний зардал нь ойролцоо байна.

Компаниудын үр ашгийг борлуулалтын орлого болон дулаан үйлдвэрлэхтэй холбоотой гарсан борлуулсан бүтээгдэхүүний өртгөөр харьцуулахад дараах байдалтай байна.

Үр ашгийн үзүүлэлт

Хүснэгт-7 (мян.төг)

№	Компанийн нэр	Борлуулалтын орлого		ББӨ		Ашиг		Ашиг/ББӨ		Ашиг/БО		БО/ББӨ		ББӨ/Талбайн хэмжээ	
		2016	2017	2016	2017	2016	2017	2016	2017	2016	2017	2016	2017	2016	2017
1	Их-Уул дулаан ХХК	324,090.4	349,414.4	234,448.4	283,234.9	2,392.4	7,606.2	0.01	0.03	0.01	0.02	1.38	1.23	7.33	7.87
2	Тариалан НАУТ ХХК	468,538.9	519,892.8	373,645.3	371,927.9	2,416.2	42,277.6	0.01	0.11	0.01	0.08	1.25	1.40	8.10	8.00
3	Тосон-Илч ХХК	251,507.7	266,062.9	230,868.4	205,978.2	(32,932.7)	(12,736.9)	(0.14)	(0.06)	(0.13)	(0.05)	1.09	1.29	10.04	7.78
4	Тэсийн-Илч ХХК	246,681.8	267,899.9	205,083.0	209,658.3	(132,162.5)	146.3	(0.64)	0.00	(0.54)	0.00	1.20	1.28	7.49	7.50
5	Галт дулаан ХХК	414,394.0	416,558.6	309,440.4	348,524.1	65,347.1	49,772.8	0.21	0.14	0.16	0.12	1.34	1.20	9.82	7.22
6	Дулаан эрдэнэт ХХК	240,134.9	260,046.8	196,456.0	205,923.0	(15,265.0)	(57,731.8)	(0.08)	(0.28)	(0.06)	(0.22)	1.22	1.26	7.98	7.67
7	Түнэл-Илч ххк	172,430.3	190,549.6	152,822.0	117,385.1	(7,856.7)	16,156.5	(0.05)	0.14	(0.05)	0.08	1.13	1.62	9.42	6.40
	Нийт дүн	2,117,777.9	2,270,425.0	1,702,763.5	1,742,631.5	(118,061.3)	45,490.8	(0.69)	0.08	(0.61)	0.04	8.62	9.28	60.2	52.5

Тооцоолол: ББӨ-ийг аудитаар жинхэнэ гүйцэтгэлээр тооцсон, талбайн хэмжээнд халаах талбайн хэмжээг авсан. Үр ашгийн үзүүлэлтийн хүснэгт-7д менежмент, удирдлагын зардал, үндсэн хөрөнгөө данснаас хассаны гарз зэрэг зардлуудыг харуулаагүй болно.

Хүснэгтээс харахад: Сумдад уурын зуухны үйл ажиллагаа явуулж байгаа компаниудын үр ашгийг тооцоход харилцан адилгүй байна. **Үүнд:**

1. Ашгийн хувьд:

- Нэгж борлуулсан бүтээгдэхүүний өртгийн 0,0- 0,21 мянган төгрөг
- Борлуулалтын орлогын 0,0-0,16 мянган төгрөг нь тус тус ашиг болж байна.

2. Борлуулсан бүтээгдэхүүний өртгийн хувьд:

- Борлуулсан бүтээгдэхүүний өртөг тутмаас 1,09-1,40 төгрөг нь борлуулалтын орлого оруулсан
- Нэгж талбайн борлуулсан бүтээгдэхүүний өртөг нь 6,40-10,04 мянган төгрөг болж байна.

Борлуулсан бүтээгдэхүүний өртгөөр тооцоход хүчин чадлын хувьд харилцан адилгүй боловч түүнд ажилтнуудын цалингийн зардал, зарцуулсан нүүрсний хэмжээ, тээврийн зардлууд нь ихэнх хувийг эзэлж байна. /Хавсралт №-2-оос харна уу/

Цалингийн зардал, тээврийн хөлсний нэгж тутамд ногдох зардал болон үр ашгийн үр дүнд хийсэн дээрх судалгаанаас харахад: **Тэсийн –Илч” ХХК** Эрчим хүчний зохицуулах зөвлөлийн 2009 оны 06 дугаар сарын 08-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор баталсан дулаан эрчим хүчний үнэ тарифын **доод хязгаараар**, бусад компаниудын хувьд эрчим хүчний үнэ тарифын одоогийн түвшинг хэвээр байлгах боломжтой байна.

Иймд: “Тэсийн –Илч” ХХК-ийн хувьд халаалтын төлбөрийг төсөвт дарамт учруулахгүйгээр төсвийн байгууллагын дулаанаар хангах гэрээний хугацааг 1 хүртэл сараар сунгах боломжтой байгааг харуулж байна.

Нэг сарын орлого, зардлын тооцоо.

Хүснэгт- 12 /сая төгрөг/

№	Үзүүлэлт	Мөнгөн дүн
1	Борлуулалтын орлого/ төсөвт байгууллагаар тооцов/	31,3 /24112,1м3/
Зардлууд:		
2	Цалин, НДШ зардал	12,7
3	Нүүрс/4-5 дугаар сард зарцуулсан нүүрсний дунджаар тооцов/	1,9 /60тн-оор/
4	Нүүрс тээврийн хөлс	0,5
5	Гэрэл цахилгааны зардал	2,2
Зардлын дүн		17,3
Зөрүү		14,0

Хүснэгтээс харахад: Тэсийн – Илч” ХХК –ийн сарын орлогын 55,2 хувьтай буюу 17,3 сая орчим төгрөгийн зардал гаргаж байгаа нь компанийн 2017 оны үр дүн /ашиг/-тай ойролцоо буюу гэрээг 1 хүртэл сараар сунгахад компанийн хэвийн үйл ажиллагаанд хүндрэлгүй байх нь харагдаж байна.

Тооцоолол: Орлогыг төсөвт байгууллагын 1 сарын халаалтын орлогоор, зардлыг бодит гүйцэтгэлтэй уялдуулан тооцов.

Сумдад уурын зуухны үйл ажиллагаа явуулж байгаа компаниудын зардлыг бууруулах боломж байна. Үүнд:

1. Нүүрс тээвэрлэлтийн зардлыг бууруулах боломж байна.

Сумдад уурын зуухны үйл ажиллагаа явуулж буй компаниудын тн,км-ийн тээврийн хөлсний зардлыг харьцуулахад:

- “Тариалан НАҮТ” ХХК тн.км-ийн тээврийн хөлс 140-170 төгрөг,
- “Түнэл илч” ХХК тн.км-ийн тээврийн хөлсийг хамгийн их буюу 200 төгрөг.
- “Тэсийн илч” ХХК –ийн тн.км-ийн тээврийн хөлс 2016 онд 409 төгрөг, 2017 онд 380 төгрөг тус тус байна.
- “Их-Уул дулаан” ХХК болон “Шинэ-Идэр дулаан эрдэнэт” ХХК –ууд нь өөрийн автомашинаар нүүрсээ тээвэрлэж байгаа нь нэгж тн.км-ийн өртөг нь “Тэсийн-Илч” ХХК-тай ойролцоо болсон байна. /Хүснэгт-5-аас харна уу/

Иймд: Нүүрс тээвэрлэх ажилд худалдан авах ажиллагааг үр дүнтэй зохион байгуулан зардлыг бууруулах боломж байна.

2. Нүүрсний зардлыг бууруулах боломжтой.

Уурын зуухны үйл ажиллагаа явуулж байгаа компаниудын нүүрсний зардал нь нийт зардлын 17,8-18 хувийг эзэлж байна.

Худалдаж авсан нүүрсний тоо хэмжээг бодитой тооцож байгааг аудитаар шалгахад тээвэрлэж ирсэн нүүрсний тоо хэмжээг жигнэх нөхцөл бүрдээгүй байна. Бэлтгэн нийлүүлэгчийн падааныг үндэслэж хүлээн авч байгаагаас харахад компаниудын **нүүрсний худалдан авалт, зарцуулалт, тоо хэмжээ бодитой эсэх нь эргэлзээтэй байна.**

Нүүрс зарцуулалт:

Хүснэгт-8

№	Компанийн нэр	Зарцуулсан нүүрс /тн-оор		
		2016	2017	Зөрүү
1	Их-Уул дулаан ХХК	1,803.0	2,023.1	220.1
2	Тариалан НАҮТ ХХК	1,920.0	2,010.1	90.1
3	Тосон-Илч ХХК	1,195.0	955.0	(240.0)
4	Тэсийн-Илч ХХК	1,143.2	1,354.0	210.7
5	Галт дулаан ХХК	1,394.8	1,600.1	205.3
6	Дулаан эрдэнэт ХХК	768.0	734.4	(33.6)
7	Түнэл-Илч ххк	610	638.0	28,0
Нийт дүн		8,834	9,314.7	480.7

Хүснэгтээс харахад: Компаниудын 2017 онд зарцуулсан нүүрсний тоо хэмжээ 480,7 тн-оор нэмэгдсэн байхад, “Тосон-илч” ХХК 240 тн-оор, “Шинэ-Идэр дулаан эрдэнэт” ХХК 33,6 тн-оор тус тус буурсан байна. Бусад компаниуд

өмнөх оноос **28,0-220,1** тн нүүрсээр илүү зарцуулсан байна.

Энэ нь нүүрсний чанар, тоо хэмжээг бодитой жигнэхгүй байгаатай холбоотой байгаа нь харагдаж байна. Хэрэв хэрэглэж байгаа нүүрс нь чанартай, тоо хэмжээг бодитой тооцож, хянавал өмнөх оны түвшингээр нүүрсээ зарцуулбал компани тус бүр 4,2-7,9 сая төгрөгөөр буюу нийт 25,3 сая төгрөгөөр зардлаа хэмнэх боломжтой байна./Хавсралт №2-оос харна уу/

Компаниудын шугамын урт, талбайн хэмжээнд үндэслэн зуухны халаах хүчин чадлыг тооцвол: “Түнэл-Илч” ХХК, “Тосон-Илч” ХХК, “Шинэ-Идэр дулаан эрдэнэт” ХХК, “Тэсийн –Илч” ХХК –ууд нь өндөр хүчин чадалтай зуухаар 1 ам /1 нөөцийн зуух байх/-аар галлахад одоо байгаа талбайг бүрэн халаах боломжтой байна. /Мэргэжлийн хүнээр тооцоог хийлгэв./ Хүснэгт -1-ээс харна уу

3. Цалингийн зардлыг ижил түвшинд тогтоох шаардлагатай байна.

Компаниудын нийт зардлын 38,8-48,6 хувийг цалингийн зардал эзэлж байна. Гүйцэтгэх захирал, нягтлан бодогч, эд хариуцагч, механик, галч машинистийн үндсэн цалингийн түвшинд хийсэн судалгааны дүнд дунджаар тооцсон цалингийн зардлаас дараах компаниудын зарим ажилтнуудын үндсэн цалин их байна.

Тухайлбал:

- “Тэсийн-Илч” ХХК-ийн машинистийн цалингаас бусад дээрх албан тушаалтнуудын цалин дунджаас 1,3-72,4 мянган төгрөгөөр,
- “Түнэл-Илч” ХХК-ийн нягтлан бодогчийн цалин 50,1 мянган төгрөгөөр
- “Шинэ-Идэр Дулаан эрдэнэт” ХХК-ийн хувьд гүйцэтгэх захирлаас бусад ажилтнуудын цалин 17,6-62,3 мянган төгрөгөөр тус тус их байна.

Иймд: Уурын зуухны үйл ажиллагаа явуулж байгаа компаниудын ажилтнуудын үндсэн цалинг нэг түвшинээр тогтоовол цалингийн зардлаас зохих хэмжээний хэмнэлт гарах, цалингийн хэмжээ адил болгох шаардлагатай байна./Хавсралт№-5-аас харна уу/

4. ТУЗ-ийн зардлыг бууруулах боломжтой.

Компаниудын ТУЗ-ийн гаргаж байгаа шийдвэрүүд нь төдийлөн үр дүнтэй биш байна гэж аудитаар үзэж байна. Иймд бизнес төлөвлөгөөгөөр баталсан 69,2 сая төгрөгийг хэмнэж, хуралд оролцсон, үр нөлөөтэй санал гаргасан зэрэг гишүүдийн оролцоогоор нь цалинжуулах нь зүйтэй гэж үзэж аудитаар байна.

Орон нутагт уурын зуухны үйл ажиллагаа явуулж байгаа компаниудын ТУЗ-ийн гишүүдэд сар бүр 105,0 мянган төгрөгийн цалин олгож, нийгмийн даатгалын шимтгэл төлж байна. Компаниудын удирдлагыг орон нутагт шилжүүлбэл ТУЗ-ийн зардлыг багасгах боломжтой байна. **Жишээ нь:** “Тэсийн илч” ХХК-ийн төлөөлөн удирдах зөвлөлийн зардлыг дараах байдлаар баталсан байна.

“Тэсийн –Илч” ХХК-ийн ТУЗ-ийн зардлын төсөв

Хүснэгт-9

№	Зардлын төсөв	Нийт зардал/мян.төг
1	ТУЗ-ийн дарга, гишүүдийн цалин	6840,0
2	НДШ	889,2
3	Бичиг хэргийн зардал	300,0
4	Хурлын зардал	300,0
5	Томилолт	900,0
6	Шатахуун	1040,0
	Нийт	10269,2

Хөвсгөл аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2017 оны 1 дүгээр сарын 20-ны өдрийн 04 дүгээр тогтоолоор орон нутгийн өмчит хязгаарлагдмал

хариуцлагатай компаниудын ТУЗ-ийн дарга, нарийн бичгийн дарга, гишүүдийн цалинг тогтоосон байна. /Хавсралт №4-өөс харна уу/

2.3. ТБОНӨХБАҮХА тухай болон Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт хангалтгүй байна.

Сумдад уурын зуухны үйл ажиллагаа явуулж буй компаниуд нүүрс худалдан авалт, нүүрс тээвэр, хөдөлмөр хамгааллын хэрэгсэл зэрэгт ТБОНӨАБАҮХАТХ-ийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасан зарчмыг баримтлахгүй, ил тод, нээлттэй, үр ашигтай байдлаар зохион байгуулаагүй байна. **Тухайлбал:**

Нүүрс худалдан авалтын тухайд: “Шинэ Идэр дулаан эрдэнэт” ХХК, “Түнэл-Илч” ХХК, “Тосон-Илч” ХХК-иуд худалдан авах ажиллагааг зохион байгуулаагүй шууд худалдан авалт хийсэн байна.

Нүүрс тээвэрлэлтийн тухайд: Нүүрс тээвэрлэлтэд худалдан авах ажиллагааг зохион байгуулсан хэдий ч гэрээнд 1 тн.км-ийн хөлсийг тодорхой тусгаагүй байна.

Түлш шатахуун, хөдөлмөр хамгааллын хэрэгслийн тухайд: “Тариалан сумын НАҮТ” ХХК нүүрс тээвэрлэх гэрээг Тэнгэрийн шугам ХХК-тай байгуулсан байна. Гэрээний үнэ 70,9 сая төгрөг гэснээс тээвэрлэх нүүрсний тоо хэмжээг тусгаагүй.

Тендерийн баримт бичигт: Шатах, тослох материал нийлүүлэх гэрээг “Хөвсгөл дуулга” ХХК-тай байгуулсан ба гэрээний үнэ 29,6 сая төгрөг гэснээс нэгжийн үнийг тодорхой заагаагүйгээс хэмнэлттэй байдлаар гэрээ байгуулагдаагүй байна. ХАА-нд шатахууны нэг бүрийн үнийг тодорхой заагаагүй, нийт үнээр гэрээ хийсэн байна.

Хүснэгт-10

Хөдөлмөр хамгааллын хувцасны үнийн жагсаалт / Түүвэрлэн харуулав/ мян.төг

Үзүүлэлт	Их-уул дулаан "ХХК"	Тосон илч ХХК	Тариалан НАҮТ ХХК	Тэсийн-Илч ХХК
Өвлийн ажлын хувцас	180,0	95,0	65,0	95,0
Өвлийн гутал	130,0	100,0	76,0	80,0

Хүснэгтээс харахад: Дээрх компаниудын хувьд хөдөлмөр хамгаалалд олгож байгаа ажлын хувцсыг харилцан адилгүй үнээр худалдаж авсан нь зардлын дүнд өөр өөр нөлөө үзүүлсэн байна.

Компаниуд шилэн дансны цахим хуудсан дахь цэсээ солиогүй байна.

Сумдад уурын зуухны үйл ажиллагаа явуулж байгаа ОНӨҮГ-уудыг аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2016 оны 12 сарын 27-ны өдрийн 98-104 дугаар тогтоолуудаар орон нутгийн өмчит ХХК болгосон нь Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйл “Хуулийн үйлчлэх хүрээ”-ний 3.1.3 (...*хяналтын багц буюу түүнээс дээш хэмжээний хувьцааг нь төр, орон нутаг болон тэдгээрийн нэгдмэл сонирхолтой этгээд эзэмшиж байгаа компани...*) дахь заалтад хамрагдан МУ-ын ЗГ-ын 2016 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.2-т заасан мэдээллүүдийг хуулийн хугацаанд нийтэд ил тод мэдээлэх үүрэгтэй болж байна.

Уурын зуухны үйл ажиллагаа явуулж байгаа “Тосон-Илч” ХХК, “Тариалан НАҮТ” ХХК, “Түнэл-Илч” ХХК, “Шинэ-Идэр Дулаан Эрдэнэт” ХХК, “Тэсийн Илч” ХХК-иуд нь 2017 онд “Шилэн дансны цахим хуудас”-нд дараах мэдээллүүдийг мэдээлэхгүй байна.

Үүнд:

- “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын **4.2.3** (...Зээл, өрийн бичиг, баталгаа түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл болон төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд байгуулсан гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулсан, өр авлага үүсгэсэн аливаа шийдвэрийг гарсан өдөр нь зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн баримтад заасан маягтын дагуу PDF Форматаар...)
- “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын **4.2.6** (...Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан маягтын дагуу PDF Форматаар ...)
- 2017 онд худалдан авах ажиллагааны төлөвлөгөө болон тендерийн ерөнхий мэдээллийг хуульд заасан хугацаанд мэдээлээгүй хугацаа хоцроосон зөрчил байна. **Тухайлбал:**

Хүснэгт-11

№	Компанийн нэрс	Шилэн дансны цахим хуудсанд мэдээлэх заалтууд	
		Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө	Тендерийн ерөнхий мэдээлэл
1	Тосон-Илч ХХК	Хугацаа хоцроож мэдээлсэн	Мэдээлээгүй
2	Тариалан НАҮТ ХХК	Мэдээлээгүй	Мэдээлсэн. /1,5 дугаар сард хугацаа хоцроосон/
3	Түнэл-Илч ХХК	Мэдээлээгүй	Дутуу мэдээлсэн
4	Шинэ-Идэр Дулаан Эрдэнэт ХХК	Тайлбар оруулсан байна.	Мэдээлсэн. /1, 2, 5, 11 дугаар саруудад хугацаа хоцроосон/
5	Галт дулаан ХХК	Хугацаа хоцроож мэдээлсэн байна.	Мэдээлсэн /1-12 11 дугаар саруудад хугацаа хоцроосон/
7	Их-Уул дулаан ХХК	Мэдээлсэн байна.	Тайлбар оруулсан /Тендерийн мэдээлэл байхгүй байна/

ОНӨҮГ-ууд нь ХХК болсон ч Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд өмнөх цэсийн дагуу мэдээллийг байршуулж байгаа нь зарим төрлийн мэдээлэл оруулахад Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 заасан төсөвт байгууллага, төрийн болон

орон нутгийн өмчит хуулийн этгээдийн байршуулах мэдээллийг оруулж байгаа нь хүндрэлтэй, өөрт хамааралгүй буруу мэдээллийг байршуулсан, мэдээллээ хугацаа хоцроосон зөрчил байна.

Уурын зуухны үйл ажиллагаа явуулж байгаа ХХК–ууд нь санхүүгийн үйл ажиллагааны анхан шатны баримтуудын бүрдүүлэлт хангалттай боловч нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд дараах алдаа зөрчил байна. **Үүнд:**

- Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиггүйгээс тавьж олгосон сэлбэг хэрэгсэл, бараа материалыг нягтлан бодох бүртгэлээс хасахгүй бүртгэсэн байна. Тухайлбал: “Тариалан НАҮТ” ХХК-ийн үйл ажиллагаанд тавьж олгосон 25,7 сая төгрөгийн сэлбэг сангийн материалыг данснаас хасаагүй байна.
- “Тариалан НАҮТ” ХХК 2016 оны 6 дугаар сард ОНХС-аас санхүүжсэн, үйл ажиллагааны бус 4,9 сая төгрөгийг орлого, 2 тогооны үнэ зэрэг нийт 65,3 сая төгрөгийн орлогыг борлуулалтын орлогоор бүртгэсэн байна.
- “Тэсийн илч” ХХК 2016 онд НӨАТ-ын хамт худалдаж авсан нүүрс, шатахуун, эрчим хүчний үнийг төлбөл зохих үнээс хасаж бүртгээгүй нийт 6,8 сая төгрөг, 2016 онд данснаас хассан уурын зуухны тогоог одоо үйл ажиллагаандаа хэрэглэж байна.
- “Тэсийн –Илч” ХХК 2016 оны эхэнд “Могойн гол” ХК-аас 3,3 сая төгрөгийн авлагыг нүүрс авснаар хааж бүртгэснийг эд хариуцагчийн тайлангаарх нүүрсний орлоготой тулгахад 3,3 сая төгрөгөөр зөрж байна. Энэ нь худалдаж авсан нүүрсийг НӨАТ-тэй үнээр орлого авч зарцуулсантай холбоотой бөгөөд компанийн бизнес төлөвлөгөөний зардлын гүйцэтгэлд нөлөөлсөн байна.
- Сумын төвийн шинэчлэлийн ажил хийгдэж 2015 оны 10 дугаар сард 3 ширхэг тогоог шинэчлэн тавьсан боловч тогоо цоорч халаалт өгөх боломжгүй байдал үүссэнтэй холбогдуулан төслийг хэрэгжүүлэгч “Сан” ХХК-аас “Тэсийн- Илч” ОНӨААТҮГ-т тогооны үнэ гэж 70,0 сая төгрөг 2016 оны 9 дүгээр сард шилжүүлсэн ба 50,0 сая төгрөгөөр 2ш тогоо худалдаж авсан ба суурилуулах болон тээврийн зардалд 20,0 сая төгрөгийг зарцуулсныг НББ-д бүртгээгүй байна. Мөн төслийн хүрээнд хэрэгжсэн УКА-45/2016 комиссын актаар хүлээн авсан 524,7 сая төгрөгийн уурын зуухны тоног төхөөрөмжийг орлого аваагүй байна.
- Тэсийн-Илч” ХХК 2017 онд бөхийн барилдааны шагналд 0,4 сая төгрөг, шаганы харвааны шагналд 0,2 сая төгрөг, 2016 онд баяр наадмын зардалд 0.2 сая төгрөгийг тус тус зарцуулсан нь УИХ-ын 2016 оны 47 дугаар тогтоолын V-ийн 5-д “Төсвийн хөрөнгөөр шууд болон шууд бус хэлбэрээр шинэ жил, баяр ёслолын аливаа арга хэмжээг санхүүжүүлэхгүй байх” заалтыг зөрчсөн байна.
- “Тосон-Илч” ХХК АНДИ-20 хуучин уурын зуухаа 2007 оноос хойш уурын зуухны барилгатай хамт 13,3 сая төгрөгөөр бүртгэсэн./Одоо ашиглаж байгаа/
- Уурын зуухны тогоог ямар хугацаанд ашиглах, үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал тооцох хугацаа нь компаниудад өөр өөр, “Тариалан НАҮТ” ХХК-ийн 2014 оноос ашигласан зуух нь ашиглалтын шаардлага хангахгүй болсон байна.

Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой дээрх алдаа, зөрчлөөс харахад компаниуд нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиггүйгээс үйл ажиллагааны бус орлогыг бүртгэх, тавьж олгосон материалыг ямар хугацаанд бүртгэлээс хасах, борлуулсан бүтээгдэхүүний өртөг тооцоололт, бүртгэл хөтлөлт хангалтгүй байна.

Иймд уурын зуухны үйл ажиллагаа явуулдаг компаниудад нэгдсэн удирдлагаар хангах нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг шаардлагатай байна.

Өмнөх зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллах, санхүүгийн LIDER програмыг бүрэн ашиглах, өртөг зардлыг бодитой тооцох зэргээр өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэхэд анхаарч ажиллаж байна.

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлт хийж байна. **Үүнд:**

1. Компанийн удирдлагыг Хувьцаа эзэмшигчдийн Хурал, ТУЗ-тэй болгосноор сум, орон нутгаас хамааралгүй болгож, эрсдэлтэй асуудлуудыг богино хугацаанд шийдвэрлэх, дүрэмд заагаагүй чиг үүргийг хэрэгжүүлэхэд хүндрэлтэй болсон байна.
2. Компаниудыг чиг үүрэг, үйл ажиллагааны чиглэл зорилгод нийцүүлэн зохион байгуулаагүй, компаниудын үр ашиг нэмэгдсэн нь ТУЗ-ийн ажлын үр дүнгээс төдийлөн хамаараагүй байна.
3. Компаниудын ТУЗ чиг үүргээ зарим талаар үр нөлөөтэй бүрэн хэрэгжүүлээгүй, бодлого шийдвэр гаргаагүй, тоног төхөөрөмжийн ашиглалтын талаар дорвитой арга хэмжээ аваагүй байна.
4. Бизнес төлөвлөгөөг батлахдаа өмнөх оны гүйцэтгэл, жилийн дундуур хийсэн өөрчлөлтийг шинжлээгүй, “Тэсийн –Илч “ХХК,“Тариалан НАҮТ” ХХК, “Галт дулаан” ХХК-иуд бизнес төлөвлөгөөгөөр баталсан зардлыг хэтрүүлж ажилласан байна.
5. Дулаан үйлдвэрлэлийн борлуулсан бүтээгдэхүүний өртгийг бууруулах, “Тэсийн-Илч” ХХК-ийн дулааны үнэ тарифыг ялгавартай тогтоох, эсвэл дулаанаар хангах гэрээний хугацааг 1 хүртэл сараар сунгах боломжтой байна.
6. ТБОНӨАБАҮХАТХ болон Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт хангалтгүй байна.
7. Орон нутгийн өмчит компаниудын санхүүгийн үйл ажиллагаанд хэрэглэх Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиггүй байна.

ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан албан тушаалтанд зөвлөж байна. **Үүнд:**

Аймгийн орон нутгийн өмчийн газрын дарга Ц.Болд-д

1. Сумдад уурын зуухны үйл ажиллагаа явуулж байгаа компаниудын удирдлага, зохион байгуулалтын талаар үр нөлөөтэй бодлого, уурын зуухнуудын шинэчлэлтэй холбоотой хөрөнгийн асуудлыг шийдвэрлэх талаар арга хэмжээ авч ажиллан аймгийн ИТХ-аар батлуулах.

Орон нутгийн өмчийн хэлтсийн дарга, сумдад уурын зуухны үйл ажиллагаа явуулж байгаа компаниудын ТУЗ-ийн дарга Н.Шинэбаяр-т:

1. Ашиглалтын хугацаа дууссан барилга, уурын зуух, шугам сүлжээ, тоног төхөөрөмжийн ашиглалт, шинэчлэлтийн байдал, техникийн усны норм дүрэм баримтлах, шугамын алдагдал зэрэгт хяналт тавьж, үр дүнтэй бодлого шийдвэр гаргаж ажиллах.
2. Уурын зуухны үйл ажиллагаа явуулж буй компаниудын орон нутаг дахь удирдлагын саналыг харгалзан компанийн дүрэмд тусгах, хамтарч ажиллах.
3. Орлого нэмэгдүүлэх, зардал бууруулах, цалин тогтоолт, үнэ тарифын талаар бодлогоор хангаж ажиллах.

Гүйцэтгэх захирал нарт:

1. Зардал бууруулах боломжуудыг бүрдүүлэн, бизнес төлөвлөгөөгөөр баталсан зардлын үр ашгийг дээшлүүлэх, УИХ-ын 2016 оны 47 дугаар тогтоолыг хэрэгжүүлэн шинэ жил болон баяр наадмын аливаа арга хэмжээг санхүүжүүлэхгүй байх
2. Худалдаж авч байгаа нүүрсний тоо хэмжээг жигнэх, хэмжих нөхцөлийг бүрдүүлж, хяналт тавьж ажиллах.
3. ТБОНӨХБАҮХАТ хууль болон Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах.
4. Усны хатуулаг бууруулах төхөөрөмж тавьж, зуух, шугам сүлжээний ашиглалт, шинэчлэлийг сайжруулах арга хэмжээ авч ажиллах.
5. Харилцагчидтай байгуулсан гэрээний үүргийг хангуулж, дулаан хэмжих хэрэгслийг суурилуулах арга хэмжээ авч ажиллах
